



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 1/60

Өлгий

Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал
олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай” журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын 2025 оны хоёрдугаар улирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, олгох урамшуулалын хувь, хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Албан хаагчдын улирлын үр дүнгийн урамшууллыг хавсралт ёсоор зохих хууль журмын дагуу тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (С.Еншигүл)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүү, хяналт-шинжилгээ, мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (А.Ерганат)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН

